



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	2
НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	8
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	9
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	9
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	12
2.3. Төсвийн тэнцэл:	13
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	14
3.1. Гадаад худалдааны эргэлт:	14
3.2. Экспорт:	15
3.3. Импорт:	17
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	19
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	19
4.2. Гадаад валютын албан нөөц:	21
4.3. Төлбөрийн тэнцэл:	22
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	23
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	23
5.2. Ажилгүйдэл:	23



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2021 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Коронавириуст халдвар /КОВИД-19/ цар тахлын улмаас гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл өөрчлөгдсөнөөр эдийн засгийн өсөлт 2020 онд огцом саарч макро түвшний голлох үзүүлэлтүүд буурч эдийн засаг агшиж байсан бол 2021 оны эхний улиралд эдийн засаг сэргэж өсөлтүүд ажиглагдаж эхэллээ.



Эдийн засаг 15.7 хувийн өсөлттэй гарлаа. ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтээ хүрсэн. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны эхний улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай тооцоологдсон нь 2016 оноос хойш хамгийн доод хэмжээндээ хүрчээ. 2020 оны эхний хагас жилд -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрсэн. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 15.7 хувиар өсөж **эдийн засаг сэргэж эхэлсэн байна.**

Нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдал буурчээ. 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна. Тайлант хугацаан дахь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 179.7 тэрбум төгрөгөөр, төлөвлөсөн дүнгээс 690.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2,627.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 26.7 хувь буюу 554.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 0.7 хувь буюу 18.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн үзүүлэлттэй байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,352.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 81.3 хувийг зарцуулж, 628.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 374.3 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарч өмнөх оны мөн үеэс өсжээ. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 602.5 сая ам.доллараар өсөж, 476.7 сая ам.долларын ашигтай гарчээ. Тэнцэл 4.8 дахин өсөхөд экспортын өсөлт 964.6 сая ам.доллар болж импортын өсөлтөөс 2.7 дахин их байгаа нь нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 25.1 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 4.7 их наяд төгрөг буюу 22.9 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс буурлаа. Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 2.5 хувь болж өмнөх сараас 0.1 пунктээр, өмнөх оны мөн үеэс 3.9 пунктээр буурсан байна.

Гадаад валютын нөөц нэмэгдлээ. Нийт албан нөөцийн хэмжээ 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 4,774.6 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 680.4 сая ам.доллар буюу 16.6 хувиар нэмэгдсэн байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар урсгал тэнцэл 207.4 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 439.3 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 170.4 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 520.5 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаа өсжээ. Үнэт цаасны арилжаагаар 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 24.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 7.4 дахин өссөн байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байна. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,849.64 төгрөгт хүрч өмнөх сар болон оны эхнээс тогтвортой байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 437.81 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, оны эхнээс 0.6 хувиар чангарсан байна.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 1,282.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 132.3 тэрбум төгрөг буюу 11.5 хувиар өссөн байна. Түүнчлэн банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 2,020.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 187.8 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар өссөн байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС



НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ


1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр оны үнээр Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 8.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.6 их наяд төгрөг буюу 22.6 хувиар өссөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон Монгол Улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн нь 2017 оны мөн үед 5.6 их наяд, 2018 оны мөн үед 6.6 их наяд, 2019 оны мөн үед 7.7 их наяд, 2020 оны мөн үед 7.2 их наяд төгрөгт хүрч байсан бол 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 8.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.6 их наяд төгрөгөөр буюу 22.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

График 1. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Нэрлэсэн ДНБ-ий дүн өсөхөд эцсийн хэрэглээ өмнөх оны мөн үеэс 0.4 их наяд төгрөгөөр буурсан ч хөрөнгийн хуримтлал 0.2 их наяд төгрөг, цэвэр экспорт 1.8 их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Эцсийн ашиглалтын аргаар: 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлэх үнээр ДНБ 3.8 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.5 их наяд төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан байна.

График 2. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, 2010 оны зэрэгцүүлэх үнээр /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Зэрэгцүүлэх үнээр тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн 2017 оны мөн үед 3.2 их наяд, 2018 оны мөн үед 3.4 их наяд, 2019 оны мөн үед 3.7 их наяд, 2020 оны мөн үед 3.3 их наяд төгрөгт хүрч байсан бол 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 3.8 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2010 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий үзүүлэлт өсөхөд эцсийн хэрэглээ 0.3 их наяд төгрөгөөр буурсан боловч хөрөнгийн нийт хуримтлал 0.2 их наяд төгрөгөөр, цэвэр экспорт 0.7 их наяд төгрөгөөр өссөн нь тус тус нөлөөлжээ.

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр ДНБ-ий 67.1 хувь нь эцсийн хэрэглээнд, 29.7 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, 3.2 хувь нь цэвэр экспортод ногдож байна.

ДНБ-ийг улирлаар харуулбал, жил бүрийн нэгдүгээр улиралд ДНБ-ий хэмжээ тухайн жилийн хамгийн бага утгыг үзүүлдэг. Харин хоёрдугаар улирлаас хойш өсдөг зүй тогтол ажиглагдаж байна. 2017-2021 оны нэгдүгээр улирлын үзүүлэлтүүдийг 5 жилийн дунджаар авч үзвэл эцсийн хэрэглээ ДНБ-ий 75.2 хувийг, хөрөнгийн нийт хуримтлал 30.4 хувийг тус тус эзэлсэн бол цэвэр экспорт сөрөг 5.6 хувь байна.

График 3. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр ДНБ-ий 67.1 хувь нь эцсийн хэрэглээнд, 29.7 хувь нь хөрөнгийн нийт хуримтлалд, 3.2 хувь нь цэвэр экспортод ногдож байна. Хөрөнгийн нийт хуримтлалын ДНБ-нд эзлэх хувийн жин өсөх хандлагатай байгаа нь материаллаг эргэлтийн хөрөнгө буурч, үндсэн хөрөнгийн нийт хуримтлал өсөж байгаатай холбоотой байна. Харин цэвэр экспорт өмнөх оны мөн үеэс өсөхөд бараа, үйлчилгээний экспорт болон импорт, түүний дотор чулуун нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, газрын тосны экспорт 74.9 хувиас 4.6 дахин өссөн нь нөлөөлжээ.

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон Дотоодын нийт бүтээгдэхүүн

График 4. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр, улирлаар /их наяд төгрөг/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ өмнөх онтой харьцуулахад өссөн нь үйлчилгээ 97.8 тэрбум, аж үйлдвэр 1,182.5 тэрбум, бүтээгдэхүүний цэвэр татвар 406.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой байна.

Хүснэгт 1. ДНБ, үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

/тэрбум төгрөг/


Бүрэлдэхүүн	2017Q1	2018Q1	2019Q1	2020Q1	2021Q1	Зөрүү
ДНБ	5,836.2	6,822.8	7,965.6	7,525.5	9,219.3	1,693.7
Хөдөө аж ахуй ойн аж ахуй загас барилт ан агнуур	185.6	222.2	236.9	272.0	278.9	6.9
Уул уурхай, олборлолт	1,615.9	1,947.0	2,359.2	1,730.6	2,707.8	977.2
Боловсруулах үйлдвэрлэл	540.9	658.0	708.2	781.2	964.0	182.8
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	159.4	183.7	198.7	231.3	253.2	21.9
Барилга	47.7	61.8	75.2	85.6	86.2	0.6
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	459.1	514.4	636.1	601.3	670.1	68.9
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	333.9	373.5	422.5	330.3	333.7	3.4
Мэдээлэл, холбоо	99.5	111.9	131.9	141.7	158.5	16.8
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1,850.2	1,984.7	2,344.2	2,537.0	2,545.8	8.7
Бүтээгдэхүүний цэвэр татвар	544.0	765.5	852.7	814.5	1,221.1	406.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ-ий 43.5 хувийг аж үйлдвэр, 40.2 хувийг үйлчилгээ, 3.0 хувийг хөдөө аж ахуй, үлдсэн 13.2 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлсэн байна.

График 5. ДНБ, нэгдүгээр улиралд үйлдвэрлэлийн аргаар, оны үнээр

2021 оны нэгдүгээр улиралд байдлаар үйлдвэрлэлийн аргаар ДНБ-ийг оны үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад бүтээгдэхүүний цэвэр татвар 49.9 хувиар, аж үйлдвэр 41.8 хувиар, үйлчилгээ 2.7 хувиар, хөдөө аж ахуй 2.5 хувиар тус тус өссөн байна.




2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 2010 оны зэрэгцүүлсэн үнээр ДНБ-ий хэмжээ 3.7 их наяд төгрөгт хүрч, бодит ДНБ-ий 45.2 хувийг үйлчилгээ, 35.0 хувийг аж үйлдвэр, 3.9 хувийг хөдөө аж ахуй, 15.9 хувийг бүтээгдэхүүний цэвэр татвар эзэлж байна.

1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:

2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ 11,459.5 мянган төгрөг байна.

2011 онд ДНБ-ий бодит өсөлт 17.3 хувь байх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 4,917.1 мянган төгрөг байж энэ үеэс нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ өсөх хандлагатай байсан. 2019 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ний өсөлт 5.2 хувьд хүрэх үед нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 11,680.6 мянган төгрөг буюу хамгийн өндөр утгандаа хүрчээ. 2020 онд нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ буурч 2019 оны мөн үеэс 1.9 хувь буюу 221.1 мянган төгрөгөөр буурч 11,459.5 мянган төгрөгт хүрсэн байна.

График 6. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ ба эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 15.7 хувиар өсөж эдийн засаг сэргэж эхэлсэн байна.

ДНБ-ий бодит өсөлт 2011-2016 онуудад тасралтгүй буурч, 2016 оны гуравдугаар улирлын байдлаар -1.4 хувь буюу хамгийн доод цэгтээ хүрсэн. Харин 2017-2019 онуудад дунджаар 6.3 хувийн өсөлттэй байсан бол 2020 оны эхний улиралд ДНБ огцом буурч -10.7 хувьтай тооцоологдсон нь 2016 оноос хойш хамгийн доод хэмжээндээ хүрчээ. 2020 оны эхний хагас жилд -9.7 хувь, гуравдугаар улирлын гүйцэтгэлээр -7.3 хувьтай гарсан бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрсэн. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монгол Улсын эдийн засаг 15.7 хувиар өсөж эдийн засаг сэргэж эхэлсэн байна.

График 7. Эдийн засгийн өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн 2016-2020 оны төлөвийг авч үзвэл, 2016-2018 оны байдлаар 1.2-7.2 хувь хүртэл тогтмол өсөж байсан бол 2019 оны хоёрдугаар улирлаас эхлэн буурчээ. 2019 оны жилийн эцсийн өсөлтийн хувийг 2018 оны мөн үетэй харьцуулахад 2.0 пунктээр буурч 5.2 хувьд хүрсэн бол 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр -5.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа. Үүнд салбаруудын оролцоог авч үзвэл: хөдөө аж ахуйн салбар 6.2 хувийн өсөлт үзүүлж бусад салбаруудын үзүүлэлт тодорхой хувиар буурснаас хамаарч нийт эдийн засаг агшихад нөлөөлсөн байна.

Харин 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар **ДНБ 15.7 хувиар өссөн нь бүтээгдэхүүний цэвэр татвар 45.3 хувиар, уул уурхай, олборлолтын салбар 34.1 хувиар, аж үйлдвэрийн салбар 13.4 хувиар, үйлчилгээ 3.6 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс өссөнтэй холбоотой байна.**

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,627.9 тэрбум төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,724.1 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 18.5 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 0.7 хувиар дутуу биелсэн бол төсвийн нийт зарлага 628.0 тэрбум төгрөг буюу 18.7 хувиар төлөвлөснөөс дутуу зарцуулагджээ.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсөв

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2021 оны нэгдүгээр улирал		Өөрчлөлт	
	Төл.	Гүйц.	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлогын дүн	2,646.4	2,627.9	-18.5	0.7
Нийт зарлагын дүн	3,352.1	2,724.1	-628.0	-18.7
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-705.7	-96.3	609.5	-86.4
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-7.7	-1.0	6.6	

Эх сурвалж: Сангийн яам

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2,627.9 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 554.1 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2,724.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 374.3 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн өөрчлөлт, 2018-2021 оны байдлаар

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Нэгдүгээр улирал				Өөрчлөлт(+/-)	
	2018	2019	2020	2021	Зөрүү	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1,810.9	2,163.4	2,073.8	2,627.9	-554.1	26.7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,836.6	1,969.1	2,349.8	2,724.1	374.3	15.9
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-25.8	194.3	-276.0	-96.3	179.7	-65.1
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-0.4	2.4	-3.7	-1.0		

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, энэ нь өмнөх оны мөн үеэс 179.7 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь 1.0 хувь болж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ДНБ-д эзлэх алдагдлын хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 96.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.0 хувьд хүрсэн нь төлөвлөсөн дүнгээс 609.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого төлөвлөсөнд хүрч биелээгүй ч нийт зарлага хэмнэгдсэн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал төлөвлөснөөс буурахад нөлөөлжээ.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 91.4 хувийг татварын орлого, 8.6 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 2,627.9 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 26.7 хувь буюу 554.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 0.7 хувь буюу 18.5 тэрбум төгрөгөөр дутуу биелсэн үзүүлэлттэй байна.

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр авч үзвэл Улсын төсөв 7.1 хувь буюу 134.0 тэрбум төгрөгөөр, Орон нутгийн төсөв 0.5 хувь буюу 3.8 тэрбум төгрөгөөр, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 11.9 хувь буюу 29.4 тэрбум

төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн бол Нийгмийн даатгалын сангийн төсөв 3.9 хувь буюу 24.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 31.2 хувь буюу 420.0 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 5.4 хувь буюу 42.8 тэрбум, нийгмийн даатгалын сангийн орлого 8.1 хувь буюу 48.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2.1 дахин буюу 111.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 4. Нэгдсэн төсвийн орлогын 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

/тэрбум төгрөг/


Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Гүйц.
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,097.8	2,013.1	833.8	830.0	619.2	643.6	246.5	217.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	167.1	110.9	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
ИРЭЭДҮЙН ӨВ САН	31.8	137.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,898.9	1,764.9	833.8	830.0	619.2	643.6	246.5	217.1
Татварын орлого	1,601.4	1,590.8	346.7	354.1	415.3	439.8	246.5	217.1
Орлогын албан татвар	494.6	420.6	234.7	230.5	0.0	0.0	0.0	0.0
Нийгмийн даатгалын орлого	0.0	0.0	0.0	0.0	415.3	439.8	246.5	217.1
Хөрөнгийн албан татвар	0.0	0.0	44.9	42.6	0.0	0.0	0.0	0.0
Нэмэгдсэн өртгийн албан татвар	575.5	651.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Онцгой албан татвар	193.8	212.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тусгай зориулалтын орлого	4.1	3.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Гадаад үйл ажиллагааны орлого	206.1	203.8	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Бусад татвар, төлбөр, хураамж	127.3	99.5	67.1	81.0	0.0	0.0	0.0	0.0
Татварын бус орлого	297.5	174.1	487.0	475.9	203.9	203.8	0.0	0.0
Нийтлэг татварын бус орлого	166.1	155.1	54.5	54.1	0.0	0.0	0.0	0.0
Хөрөнгийн орлого	0.0	0.0	0.2	0.3	0.0	0.0	0.0	0.0
Тусламжийн орлого	35.3	19.0	4.8	1.4	203.9	203.8	0.0	0.0
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	96.1	0.0	427.5	420.1	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Сангийн яам

Татварын орлого 2,401.6 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 0.4 хувь буюу 9.3 тэрбум төгрөгөөр давж биелжээ.

Татварын орлогын 27.1 хувийг орлогын албан татвар, 19.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.8 хувийг хөрөнгийн албан татвар, 27.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.8 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 8.5 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 7.5 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

График 8. Татварын орлого /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Сангийн яам

Тайлант хугацаанд татварын орлого 0.4 хувь буюу 9.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татвар тус тус төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд татварын орлого 0.4 хувь буюу 9.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь нийгмийн даатгалын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар болон онцгой албан татвар тус тус төлөвлөснөөс давж биелсэнтэй холбоотой байна. Төлөвлөгөөтэй харьцуулахад орлогын албан татвар 78.2 тэрбум төгрөг (10.7 хувь), хөрөнгийн албан татвар 2.4 тэрбум төгрөг (5.2 хувь), тусгай зориулалтын орлого 0.8 тэрбум төгрөг (18.6 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 2.3 тэрбум төгрөг (1.1 хувь), бусад татвар, төлбөр хураамж 13.9 тэрбум төгрөг (7.1 хувь)-иар тус тус төлөвлөснөөс дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Нийгмийн даатгалын орлого 12.5 тэрбум төгрөг (2.8 хувь), нэмэгдсэн өртгийн албан татвар 75.9 тэрбум төгрөг (13.2 хувь), онцгой албан татвар 18.4 тэрбум төгрөг (9.5 хувь)-иар тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 489.0 тэрбум төгрөг буюу 25.6 хувиар нэмэгдэхэд нийгмийн даатгалын орлого 2.8 тэрбум (0.6 хувь), тусгай зориулалтын орлого 0.1 тэрбум (3.6 хувь) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 104.4 тэрбум (19.1 хувь), хөрөнгийн албан татвар 10.3 тэрбум (31.9 хувь), нэмэгдсэн өртгийн албан татвар 258.6 тэрбум (65.8 хувь), онцгой албан татвар 32.7 тэрбум (18.2 хувь), гадаад үйл ажиллагааны орлого 55.1 тэрбум (37.1 хувь), бусад татвар, төлбөр, хураамж 30.8 тэрбум (20.6 хувь) төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 226.3 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 40.3 хувь буюу 65.0 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 27.7 тэрбум төгрөг буюу 10.9 хувиар дутуу төвлөрчээ.

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 36.3 сая төгрөгөөр давж биелсэн хэдий ч гадаад хандив тусламжийн орлого 16.4 тэрбум төгрөгөөр, нийтлэг татварын бус орлого 11.4 тэрбум төгрөгөөр; түүн дотроо төсөвт байгууллагын өөрийн орлого 3.9 тэрбум төгрөгөөр, хүүгийн орлого 6.9 тэрбум төгрөгөөр, түрээсийн орлого 0.2 тэрбум төгрөгөөр, навигацийн орлого 15.0 тэрбум, бусад орлого 5.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн нь нөлөөлжээ. Харин хувьцааны ногдол ашиг 13.3 тэрбум төгрөгөөр, торгуулийн орлого 2.5 тэрбум төгрөгөөр, газрын тосны орлого 4.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөгөөг давуулан биелүүлжээ.

Татварын бус орлогын 92.4 хувийг нийтлэг татварын бус орлого, 7.4 хувийг тусламжийн орлого, 0.1 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 41.5 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.3 хувийг газрын тосны орлого, 9.6 хувийг торгуулийн орлого, 8.9 хувийг бусад орлого, 6.9 хувийг навигацийн орлого, 6.4 хувийг хувьцааны ногдол ашиг, 4.0 хувийг хүүгийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна.

График 9. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:

Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 3,352.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 81.3 хувийг зарцуулж 628.0 тэрбум төгрөгийг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 374.3 тэрбум төгрөг буюу 15.9 хувиар өссөн байна.

Тайлант хугацаанд төлөвлөснөөс Улсын төсвийн зарлага 437.8 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 413.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсан бол нийгмийн даатгалын сангийн зарлага 76.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 22.4 тэрбум төгрөгөөр тус тус илүү зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс Улсын төсвийн нийт зарлага 332.9 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 51.2 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 101.4 тэрбум төгрөгөөр тус тус илүү зарцуулагдсан бол орон нутгийн төсвийн зарлага 42.9 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны мөн үе	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө биелэлт, %	Өөрчлөлт	
	2021 оны нэгдүгээр улирал			Төл./Гүйц.	Зөрүү	Хувь
	1	2	3	(3:1)	(2-3)	(2-3)/2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,349.8	3,352.1	2,724.1	81.3%	374.3	15.9
НИЙТ ЗАРЛАГА	2,373.5	3,691.2	2,703.4	73.2%	329.9	13.9
УРСГАЛ ЗАРДАЛ	2,132.6	3,152.6	2,401.0	76.2%	268.4	12.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	964.5	1,294.3	880.6	68.0%	-83.9	-8.7
ХҮҮ	185.3	208.8	132.4	63.4%	-52.9	-28.5
ТАТААС	88.5	125.1	79.0	63.1%	-9.5	-10.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	894.3	1,524.5	1,309.0	85.9%	414.7	46.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	240.9	538.6	302.4	56.1%	61.5	25.5
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-23.7	-339.1	20.7	-6.1%	44.4	187.3

Эх сурвалж: Сангийн яам

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн өнгөрсөн оны мөн үеэс 15.9 хувь буюу 374.3 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 12.6 хувь буюу 268.4 тэрбум, хөрөнгийн зардал 25.5 хувь буюу 61.5 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 1.9 дахин өссөн буюу 44.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зээлийн үйлчилгээний төлбөр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 52.9 тэрбум төгрөг буюу 28.6 хувиар буурсан бол тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 76.4 тэрбум төгрөгөөр буюу 36.6 хувиар дутуу зарцуулалттай гарсан байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 88.1 хувь буюу 2,401.0 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 36.7 хувийг бараа, ажил, үйлчилгээний зардал, 54.5 хувийг урсгал шилжүүлэг, 5.5 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.3 хувийг татаас эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 268.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: бараа, ажил, үйлчилгээний зардал 83.9 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 52.9 тэрбум, татаас 9.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан ч урсгал шилжүүлэг 414.7 тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

2.3. Төсвийн тэнцэл:

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 96.3 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарсан байна.

Хүснэгт 6. Төсвийн тэнцэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирлын байдлаар					Өөрчлөлт(+/-)	
						2021.03/2020.03	
	2017	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл	-255.1	-25.8	194.3	-276.0	-96.3	179.7	-65.1
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-4.4	-0.4	2.4	-3.7	-1.0		

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 408.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан ч орон нутгийн төсөв 269.4 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсөв 15.3 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 27.7 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 315.3 тэрбум төгрөг төлж, 211.9 тэрбум төгрөгийн гадаад төслийн зээл шинээр авч, 507.2 сая төгрөгийн өмч хувьчлалын орлого төвлөрүүлжээ. Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд шинээр гаргаагүй байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА

3.1. Гадаад худалдааны эргэлт:

2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт өнгөрсөн оны мөн үеэс 60.4 хувь буюу 1,326.7 сая ам.доллараар өсөж гадаад худалдааны тэнцэл 476.7 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Монгол Улс дэлхийн 119 улстай гадаад худалдаа хийсэн байна. Экспорт 964.6 сая ам.доллар буюу 93.1 хувиар, импорт 362.1 сая ам.доллар буюу 31.2 хувиар тус тус өмнөх оны мөн үеэс өссөн байна.

Хүснэгт 7. Гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өөрчлөлт	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Нийт эргэлт	2,612.9	3,057.4	2,197.4	3,524.1	1,326.7	60.4
-Экспорт	1,482.4	1,771.7	1,035.8	2,000.4	964.6	93.1
-Импорт	1,130.5	1,285.7	1,161.6	1,523.7	362.1	31.2
Тэнцэл	351.9	485.9	-125.8	476.7	602.5	478.9

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 602.5 сая ам.доллараар өсөж 476.7 сая ам.долларын ашигтай гарчээ. Тэнцэл 4.8 дахин өсөхөд экспортын өсөлт 964.6 сая ам.доллар болж импортын өсөлтөөс 2.7 дахин их байгаа нь нөлөөлсөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл: Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2021 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 527.1 сая ам.доллараар өсөж 497.7 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл нийт бараа эргэлтийн 69.3 хувь буюу 2,440.8 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12.4 хувь буюу 437.4 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар, БНХАУ-тай хийсэн худалдаа 97.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 8. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Улс	Төрөл	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өөрчлөлт (+/-)	
		Эзлэх хувь	2019	2020	2021	2021.03/2020.03	
						Зөрүү	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	69.3	1,887.7	1,237.0	2,440.8	1,203.8	97.3
	Экспорт	92.5	1,518.6	904.7	1,849.7	945.0	104.4
	Импорт	38.8	369.1	332.3	591.2	258.9	77.9
	Тэнцэл		1,149.5	572.4	1,258.5	686.1	119.9
ОХУ	Нийт эргэлт	12.4	377.9	400.6	437.4	36.8	9.2
	Экспорт	1.4	14.9	11.0	27.8	16.8	152.9
	Импорт	26.9	363.0	389.6	409.6	20.0	5.1
	Тэнцэл		(348.1)	(378.6)	(381.8)	(3.2)	0.8
Бусад	Нийт эргэлт	18.3	791.8	559.7	645.9	86.1	15.4
	Экспорт	6.1	238.2	120.1	122.9	2.8	2.4
	Импорт	34.3	553.7	439.6	522.9	83.3	18.9
	Тэнцэл		(315.5)	(319.5)	(400.0)	(80.4)	25.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Цаг үеийн онцгой байдлаас шалтгаалж 2020 оны мөн үед БНХАУ-тай хийсэн экспортын худалдаа 19.1 хувиар, ОХУ-тай хийсэн экспортын худалдаа 15.9 хувиар буурч байсан бол 2021 оны эхний улиралд эргэн нэмэгдэж байна.

2020 оны эхний улиралд ОХУ-тай хийсэн импортын худалдаа 19.1 хувиар, БНХАУ-тай хийсэн импортын худалдаа 7.3 хувиар, бусад орнуудтай хийсэн импортын худалдаа 15.1 хувиар тус тус буурч байсан бол 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар сэргэж 5.1-77.9 хувиар нэмэгдсэн байна.

Монгол Улсын гадаад худалдаа БНХАУ-тай ашигтай, ОХУ болон бусад (Иран, Ливан, Египет, Угандагаас бусад) орнуудтай алдагдалтай гарсан бөгөөд нийт худалдааны ашиг 2020 онтой харьцуулахад 4.8 дахин нэмэгдсэн байна.

3.2. Экспорт:

Экспортын худалдааны 88.8 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 11.2 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 1,776.2 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 890.2 сая ам.доллар буюу 100.5 хувиар өссөн бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 224.2 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 74.4 сая ам.доллар буюу 49.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 9. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,252.5	1,478.9	886.0	1,776.2	890.2	100.5	88.8
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	229.9	292.7	149.8	224.2	74.4	49.7	11.2
Нийт экспорт	1,482.4	1,771.7	1,035.8	2,000.4	964.6	93.1	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Экспортын орлогын 10-аас багагүй хувийг эзэлдэг бүтээгдэхүүнд зэсийн баяжмал, нүүрс болон төмрийн хүдэр багтаж байна.

График 10. Нүүрс, зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн экспорт /тэрбум ам.дол/





График 11. Газрын тос, цайрын баяжмал болон алтны экспорт /тэрбум ам.дол/



Хүснэгт 10. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Барааны төрөл	Хэмжих нэгж	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өмнөх оны мөн үеэс	
		2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	мян.тн	337.7	361.4	306.6	316.3	9.8	3.2
Нүүрс	сая.тн	6.6	7.7	3.1	6.7	3.6	113.7
Төмрийн хүдэр	сая.тн	1.4	2.1	2.1	1.9	-0.1	-7.2
Цайрын баяжмал	мян.тн	32.9	44.0	36.9	31.0	-5.9	-16.0
Алт	тн	2.9	4.7	1.6	0.4	-1.1	-71.6
Боловсруулаагүй нефть	сая. баррель	1.6	1.6	0.3	1.4	1.1	341.2
Катодын зэс	мян.тн	3.5	2.3	3.1	3.3	0.2	6.5
Адууны мах	мян.тн	6.0	5.8	2.7	4.2	1.5	55.1
Өлөн гэдэс	тн	98.1	102.0	125.5	171.4	45.9	36.6
Үхэр, адууны боловсруулсан шир	сая.дм2	26.9	18.6	19.7	1.0	-18.7	-95.1
Үхэр, адууны боловсруулаагүй шир	мян.ш	0.3	0.0	62.0	355.6	293.6	473.5
Хонь, хурганы боловсруулсан арьс	сая.дм2	20.6	6.3	9.3	3.8	-5.6	-59.7
Ямаа, ишигний боловсруулсан арьс	сая.дм2	64.8	72.8	48.5	30.0	-18.5	-38.1
Самнасан ноолуур	тн	12.4	11.9	45.0	58.9	13.9	30.8
Бохир ноолуур	тн	4.4	24.4	17.9	355.1	337.2	1,885.6
Хонины самнаагүй ноос	мян.тн	1.4	3.2	1.6	3.0	1.3	82.2
Жоншны баяжмал	мян.тн	78.3	110.6	137.1	194.1	57.0	41.6

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Хүснэгт 11. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

(сая ам.доллар)

Барааны төрөл	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өмнөх оны мөн үеэс	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зэсийн баяжмал	462.5	503.7	351.2	621.1	269.9	76.9
Нүүрс	509.4	641.7	252.4	688.7	436.3	172.8
Төмрийн хүдэр	63.9	106.5	141.1	238.5	97.5	69.1
Цайрын баяжмал	60.2	62.6	48.3	46.4	-1.9	-3.9
Алт	124.3	195.9	80.4	25.7	-54.7	-68.1
Боловсруулаагүй нефть	101.0	87.8	17.7	78.4	60.7	342.9
Катодын зэс	23.6	13.7	17.3	27.3	10.0	57.9
Адууны мах	12.7	10.6	5.5	8.6	3.0	55.0
Өлөн гэдэс	1.6	2.4	2.2	3.8	1.6	71.0
Үхэр, адууны боловсруулсан шир	2.9	1.8	1.8	0.4	-1.4	-77.2
Үхэр, адууны боловсруулаагүй шир	0.01	0.0	0.1	0.6	0.5	408.6
Хонь, хурганы боловсруулсан арьс	0.6	0.1	0.2	56.2	-0.1	-70.9
Ямаа, ишигний боловсруулсан арьс	2.6	2.4	2.0	1.0	-0.9	-46.5
Самнасан ноолуур	0.3	0.6	4.0	3.3	-0.7	-17.1
Бохир ноолуур	0.2	2.3	0.8	11.2	10.4	1,291.6
Хонины самнаагүй ноос	2.0	5.5	1.7	2.9	1.3	76.0
Жоншны баяжмал	25.0	40.6	35.3	42.6	7.3	20.8
Нийт экспортод эзлэх хувь	94.0%	94.7%	92.9%	90.0%		

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Нүүрс: 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 6.7 сая тонн нүүрс экспортолж, 688.7 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын орлого 436.3 сая ам.доллараар буюу 2.7 дахин өссөн байна. 1 тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар өссөн, тоо хэмжээ 2.1 дахин нэмэгдсэн нь нүүрсний экспортын орлогыг өсөхөд нөлөөлжээ.

Зэсийн баяжмал: 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 76.9 хувь буюу 269.9 сая ам.доллараар нэмэгдэж, 621.1 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 316.3 мянган тонн болж, өнгөрсөн оны мөн үеэс 3.2 хувь буюу 9.8 мянган тонноор өссөн ба экспортын дундаж үнэ нь 71.4 хувиар нэмэгдсэн байна.

Нефть: 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 1.4 сая баррель нефть экспортолж, 78.4 сая ам.долларын экспортын орлого олжээ. Нефтийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 60.7 сая ам.доллараар өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нефтийн экспортын дундаж үнэ 0.4 хувиар өссөн, экспортын тоо хэмжээ 4.4 дахин өссөн зэрэг нь нефтийн экспортын орлого өсөхөд нөлөөлсөн байна.

Төмрийн хүдэр: 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 1.9 сая тоннд хүрч, 238.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 69.1 хувь буюу 97.5 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 7.2 хувь буюу 0.1 сая тонноор буурсан боловч, 1 тонн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 82.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.3. Импорт:

Нийт импортын 18.2 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 81.8 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 276.8 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 7.2 сая ам.доллараар буюу 2.5 хувиар буурсан байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,246.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 369.4 сая ам.доллар буюу 42.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 12. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирал				Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2018	2019	2020	2021	Зөрүү	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	278.8	315.4	284.0	276.8	-7.2	-2.5	18.2
Эрдсээс бусад бүтээгдэхүүн импорт	851.6	970.3	877.5	1,246.9	369.4	42.1	81.8
Нийт импорт	1,130.5	1,285.7	1,161.6	1,523.7	362.1	31.2	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд авто, агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт 22.8 хувь, эрдэс бүтээгдэхүүний импорт 18.2 хувь, машин, механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн импорт 17.3 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйлийн импорт 16.3 хувь, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 6.5 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 13. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/

Бүтээгдэхүүн	Жил бүрийн нэгдүгээр улирал						Өөрчлөлт (Сая ам.дол)
	2019		2020		2021		2021/2020
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	
Хэрэглээ	351	27%	317	27%	446	29%	129
-Түргэн эдэлгээтэй	170	13%	175	15%	252	17%	77
-Удаан эдэлгээтэй	181	14%	142	12%	194	13%	52
Хөрөнгө оруулалт	519	40%	461	40%	634	42%	173
-Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	375	29%	323	28%	469	31%	146
-Барилгын материал	104	8%	97	8%	107	7%	10
-Хөрөнгө оруулалтын бусад бараа	41	3%	41	3%	58	4%	17
Аж үйлдвэрлэлийн орц	147	11%	143	12%	210	14%	66
-Цахилгаан эрчим хүч	37	3%	38	3%	41	3%	3
Нефтийн бүтээгдэхүүн	267	21%	239	21%	230	15%	-9
-Дизель	163	13%	125	11%	136	9%	11
-АИ-92, 95	69	5%	63	5%	50	3%	-13
-А80 ба бусад	35	3%	50	4%	44	3%	-6

Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өнгөрсөн оноос 129 сая ам.доллараар өсөхөд хүнсний импорт 62 сая ам.доллараар болон автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 27 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт өмнөх оноос 173 сая ам.доллараар өсөхөд суудлаас бусад машин, механизм, тоног төхөөрөмж, тэдгээрийн эд ангийн импорт 138 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.

ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**4.1. Мөнгөний нийлүүлэлт:**

Мөнгөний нийлүүлэлт 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 25.1 их наяд төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 4.7 их наяд төгрөг буюу 22.9 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд бараг мөнгө 3,822.3 тэрбум төгрөгөөр буюу 22.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. Валютын хадгаламж 689.0 тэрбум төгрөг буюу 18.7 хувиар өссөн бол валютын харилцах 317.5 тэрбум төгрөг буюу 12.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 14. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2021.03/2020.03	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (M2)	16,073.9	19,699.6	20,451.8	25,136.0	4,684.2	22.9%
Бараг мөнгө	13,297.2	16,032.9	16,985.6	20,807.9	3,822.3	22.5%
-Төгрөгийн хадгаламж	8,859.4	11,147.8	10,720.5	14,171.4	3,450.9	32.2%
-Валютын хадгаламж	2,513.2	2,896.8	3,686.2	4,375.2	689.0	18.7%
-Валютын харилцах	1,924.6	1,988.3	2,578.9	2,261.4	-317.5	-12.3%
M1 мөнгө	2,776.7	3,666.6	3,465.2	4,328.0	862.8	24.9%
Гүйлгээнд гарсан бэлэн мөнгө	840.4	897.8	847.8	1,006.0	158.2	18.7%

Эх сурвалж: Монголбанк

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 17.6 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 489.9 тэрбум төгрөг буюу 2.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 15. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Жил бүрийн нэгдүгээр улирлын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
					2021.03/2020.03	
	2018	2019	2020	2021	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	14,139.5	17,461.9	17,146.5	17,636.4	489.9	2.9%
-Хэвийн зээл	11,971.8	14,683.0	14,163.3	14,333.1	169.8	1.2%
-Хугацаа хэтэрсэн зээл	935.9	913.7	1,150.3	1,282.5	132.2	11.5%
-Чанаргүй зээл	1,231.8	1,865.2	1,832.9	2,020.7	187.8	10.2%
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	8.7	10.7	10.7	11.5	0.8	7.2%
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх %	6.6	5.2	6.7	7.3	0.6	8.4%

Эх сурвалж: Монголбанк


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 1,282.5 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 132.3 тэрбум төгрөг буюу 11.5 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 7.3 хувь, хэвийн зээлийн 8.9 хувийг тус тус эзэлжээ. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 78.1 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн зээл, 21.8 хувийг иргэдийн зээл тус тус эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 2,020.7 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 187.8 тэрбум төгрөг буюу 10.2 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 11.5 хувь, хэвийн зээлийн 14.1 хувийг эзэлсэн байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 24.9 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс гүйлгээ 7.4 дахин өссөн байна. Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар гүйлгээ хийгдээгүй бол хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2021 оны 3 дугаар сард дунджаар 33,952.24 болж, өмнөх оны мөн үеэс 15,744.0 нэгж буюу 86.5 хувиар өсжээ.

Валютын ханш: 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 2,849.64 төгрөгт хүрч өмнөх сар болон оны эхнээс тогтвортой байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 437.81 төгрөг болж өмнөх сараас 0.8 хувиар, оны эхнээс 0.6 хувиар чангарсан байна.


График 12. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юаны дундаж ханш, төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглээний үнийн улсын индекс 2021 оны нэгдүгээр улирлын эцэст 2.5 хувь болж өмнөх сараас 0.1 пунктээр, өмнөх оны мөн үеэс 3.9 пунктээр буурсан байна.


График 13. Инфляцын түвшин, хувиар



Эх сурвалж: Монголбанк

4.2. Гадаад валютын албан нөөц: Нийт албан нөөцийн хэмжээ 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 4,774.6 сая ам.долларт хүрээд байна. Гадаад валютын албан нөөц өмнөх оны мөн үеэс 680.4 сая ам.доллар буюу 16.6 хувиар нэмэгдсэн байна. Монголбанкнаас Гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийг нэмэгдүүлэх зорилгоор алт худалдан авалтаар нийт 405.3 тэрбум төгрөг, гадаад валют худалдаж авснаар 1,378.0 тэрбум төгрөг, своп арилжаагаар 83.2 тэрбум төгрөгийг тус тус нийлүүлжээ. Эдгээрийн үр дүнд ГВУН энэ оны 3 дугаар сарын байдлаар 4.8 орчим тэрбум ам.долларт хүрч, оны эхнээс 240.4 сая ам.доллараар буюу 5.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 680.4 сая ам.доллараар буюу 16.6 нэгж хувиар нэмэгдсэн байна.

График 14. Нийт албан нөөц, сая ам.доллар



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 4,774.6 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 9.7 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Хүснэгт 16. Гадаад валютын албан нөөц ба импорт


/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	2016.03	2017.03	2018.03	2019.03	2020.03	2021.3
1	Нийт импорт	599.1	776.2	1,130.5	1,285.7	1,161.6	1,523.7
2	Гадаад валютын нийт нөөц	1,265.3	1,109.2	2,983.1	3,660.4	4,094.2	4,774.6
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	7.0	4.8	8.4	8.9	11.7	9.7

Эх сурвалж: Монголбанк, Үндсэний статистикийн хороо

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2021 оны жилийн нэгдүгээр улирлын эцэст 2.9 тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.4 тонноор буурсан байна. 2021 оны 3 дугаар сарын хувьд Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 27.5 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 35.5 кг үнэт металл худалдан авсан. Монголбанкны 1 грамм алт худалдан авах дундаж ханш 2021 оны 3 дугаар сард 157,543.30 төгрөг байжээ.

График 15. Монголбанкны худалдан авсан алт, кг



4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар урсгал тэнцэл 207.4 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 439.3 сая ам.долларын илүүдэлтэй, төлбөрийн тэнцэл 170.4 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 520.5 сая ам.доллараар өссөн байна.

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар урсгал тэнцлийн алдагдал 207.4 сая ам.доллар, үүний дотор цэвэр урсгал шилжүүлэг 54.1 сая ам.доллар гарсан бол бараа ба үйлчилгээ 123.0 сая ам.долларын илүүдэлтэй, цэвэр орлого 384.5 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал тэнцлийн алдагдал 515.9 сая ам.доллараар буурсан байна. Урсгал тэнцлийн алдагдал буурахад бараа ба үйлчилгээний алдагдал 792.3 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ.

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар хөрөнгө ба санхүүгийн тэнцэл 439.3 сая ам.долларын илүүдэлтэй гарсан нь өмнөх оны мөн үеэс 108.3 сая ам.доллараар өссөн байна. Төлбөрийн тэнцэл 170.4 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 520.5 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

Хүснэгт 17. Төлбөрийн тэнцэл, 2019.03 - 2021.03

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Гүйцэтгэл			Нэгдүгээр улирлын өөрчлөлт (+/-)	
	2019.03	2020.03	2021.03	2020/2019	2021/2020
I. Урсгал Тэнцэл	-398.1	-723.2	-207.4	-325.2	515.9
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-182.7	-669.3	123.0	-486.6	792.3
В. Орлого	-288.6	-129.2	-384.5	159.4	-255.3
С. Урсгал шилжүүлэг (цэвэр)	73.2	75.2	54.1	2.0	-21.1
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	582.2	331.0	439.3	-251.3	108.3
А. Хөрөнгийн данс	24.7	25.1	30.9	0.4	5.8
В. Санхүүгийн данс	557.6	305.9	408.4	-251.7	102.5
III. Алдаа болон орхигдуулга	35.4	42.1	-61.6	6.7	-103.7
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	219.6	-350.2	170.4	-569.8	520.5

Эх сурвалж: Монголбанк

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

5.1. Хүн ам, ажил эрхлэлт:

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар хүн амын улсын ээлжит тооллогын дүнд Монгол Улсын хүн ам 3 357 542, өрхийн тоо 908 712 болсон байна. 2021 оны нэгдүгээр улиралд Улсын хэмжээнд 17.6 мянган эх амаржиж, 17.8 мянган хүүхэд шинээр төрж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 0.9 мянга буюу 4.9 хувиар, төрсөн хүүхэд 0.9 мянга буюу 4.9 хувиар тус тус буурчээ. Хүн амын тоо 2010-2021 оны хооронд жилд дунджаар 2.2 хувиар өсжээ.


Ажиллах хүчний судалгааны 2021 оны нэгдүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15 ба түүнээс дээш насны 2,105.81 мянган хүн байгаагийн 975.4 мянга буюу 46.3 хувь нь эрэгтэй, 1,130.4 мянга буюу 53.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 19.4 мянга буюу 0.9 хувиар буурсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн 23.3 мянган хүнээс 15.5 мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 7.8 мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна. Өмнөх онтой харьцуулахад бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 20.3 хувь буюу 3932-оор буурсан байна.

2021 оны нэгдүгээр улирлын байдлаар 15 ба түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1,253.1 мянга болж, өмнөх оноос 43.6 мянган хүнээр буурсан байна. Ажиллах хүчний оролцооны түвшин 59.0 хувь болж өнгөрсөн оноос 1.7 пунктээр буурсан байна. Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны нийт хүн амын 949.7 мянга буюу 45.1 хувь нь эдийн засгийн идэвхгүй хүн ам, тэдгээрийн 108.8 (11.5%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх, эсхүл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүчинд багтаж байна.

5.2. Ажилгүйдэл:

График 16. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр, хүйсээр, дүнд эзлэх хувиар




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Улсын хэмжээнд 2021 оны нэгдүгээр улирлын байдлаар ажилгүй хүн 101.2 мянга байна. Үүнээс: 59.8 (59.2%) мянга нь эрэгтэйчүүд, 41.3 (40.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 18.5 (22.4%) мянгаар өссөн байна.

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 8.8 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 9.8 хувь, эмэгтэйчүүдийнх 7.6 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 10.6 хувь буюу улсын дунджаас 1.9 пунктээр дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.1 хувь байгаа нь улсын дунджаас 3.7 пунктээр доогуур байна.

График 17. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Ажилгүй иргэдийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй иргэд нийт ажилгүйчүүдийн 64.6 хувь байгаа бол үлдсэн 35.4 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

